


МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 9/213

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Хэнтий аймгийн Хэрлэн суманд Халдвартын эмнэлгийн их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Дарханбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Үнэнбат Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: М.Хишигбаяр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Х.Гонгор Иргэний төлөөлөл

Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

